

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Балдангийн Дашням	Дугаар	L072
Оршин суугаа аймаг	Дорнод	Оршин суугаа сум	Цагаан-Овоо сум
Төрсөн газар	Цагаан-Овоо сум	Төрсөн он	1928
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Цагаан-Овооны хийд	Сүм хийдийн дугаар	ДОЦО 024
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 3	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын Цагаан-Овооны хийд

Цагаан-Овоо сумын нутагт ямар ямар сүм хийд байсан бэ?

Энэ Цагаан-Овоо сумын нутагт ердөө ганцхан хийд байсан. Урд 1-р багийн нутагт байсан хийд. Өшөө юм байгаагүй.

-1-р багийн нутагт байсан хийд маань ямар нэртэй юу гэдэг хийд байсан бэ?

Хийдийн нэр гэх юм байсан юм гэж үү? Би одоо мэдэхгүй юм байна штээ. Тийм хийд гэж мэдэхгүй л юм аа. Ер нь яагаад ч мэдэхгүй юм байна.

-Хэдэн дугантай, хэр олон ламтай, ямархуу хуралтай хийд байсан бэ?

Дажгүй ламтай. Цагаан-Овоогийн лам нар гэж 50, 60 лам байсан байх. Бусад халх сумдаас лам нар зөндөө байсан л даа. Хийдийн анхны их лам 34 онд тогтсон. Тэгэхдээ Сэдээ гавж гэдэг лам толгойлж байсан. Гавж хүн байсан байх аа.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Хэдэн дугантай байсан бэ?

Юун дуган байх вэ? Ердөө л эсгий гэрт хурна. Ганцхан дуган гэдэг юм буй болсон. Цагаан-Овоо сумын хуучин захиргаанд сүүлд бий болсон. Тэгээд хэлмэгдэл эхэлсэн. Тэнд сууж байсан лам нараас баригдаагүй лам гэж үлдээгүй. Бүгд баригдаад.

-Ер нь Цагаан-Овоо сумын нутагт байсан хийдүүд гэвэл Эрдэнэ гүний хийд гэж байна?

Эрдэнэ гүний хийд гэдэг чинь хуучин байсан эндхийн халхчуудын хийд юм л даа. Манайхны баруугаар байсан улсууд тэр хийдийн сан мөргөлд очиж л байсан. Баруугаар байсан. Зүүгээр байсан Цагаан-Овоо, Галын голын адаг, одоо Хэрлэнгийн гол хавиас Эрдэнэ гүнээс ийш явдаггүй байсан. Хэрлэнгийн тэнд чинь Саруул гүний хийд гэж байлаа шүү дээ. Халх нутгийн. Эрдэнэ гүний хийд, Саруул гүний хийд гэдэг чинь Цагаан-Овоо сумын дэвсгэр нутаг юм л даа одоо.

-За одоо

Цагаан-Овооны хийдийн тухай ямар урсгалын хийд байсан бэ?

Шарын шашны хийд байсан.

-Халхчуудын байгуулсан хийд үү? Буриадуудын байгуулсан хийд үү?

Буриадын. Жинхэнэ буриадын байгуулсан хийд. Буриадын лам нар гэж Халх голоос 20 лам ирсэн.

Цагаан-Овоогийн хийд хэдэн онд байгуулагдсан хийд вэ?

Буриадууд Октябрийн хувьсгалаар дүрвээд 1904 онд Халх гол руу нүүж ирсэн юм. Халх голд байж 34 онд наашаа нүүгээд 1936 онд баруунтай Түмэндэлгэр уулын өвөрт Галуут сум гэж тогтсон юм. Хийд байхгүй. Тэгээд нэг хоёр жил болохнээ болиод цаад Эрдэнэ гүний улсууд салаад Түмэндэлгэр сум гэж болоод тэнд байсан хэдэн буриад нь Цагаан-Овоо сум гэж болоод одоо хуучин 1-р багийн төв дээр суусан.

-Бид нэг судалгаан дээр тулгуурлаж яваа. Тэнд энэ сумын нутагт хоёр хийдийг тэмдэглэсэн байгаа. Нэг нь Эрдэнэ гүний хийд, нэг нь Цорж ламын хийд гэсэн байгаа. Цорж ламын хийд гэж Цагаан-Овооны хийдээ хэлж байна уу? Аль эсвэл урагшаа өөр хийд байсан юм уу?

Ямар хийд гэнэ ээ?

Цорж ламын хийд. Газрын зураг дээр байрласнаар бол Саруул гүнээсээ зүүн тийшээ байгаа юм.

Танд сонссон дуулсан юм байна уу?

Мэдэхгүй юм байна.

-Таны баттай мэдэхээр Цагаан-Овооны хийд гэж байсан юм байна?

Ердөө ганцхан модон байшинтай, дандаа эсгий гэртэй, учиргүй том гэдэстэй шар лам нар зөндөө л байдаг байсандаг.

-Тэр хийдэд алдартай цорж лам нь энэ тэр гэж байсан уу?

Байхгүй ээ. Гавжаас дээш мяндаг цолтой буриад лам гэж ердөө байгаагүй. Сэдээ гавж л гэж байсан.

-Тэр хүн маань хийдийн тэргүүн лам нь байсан юм уу?

Тэргүүн.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Дараагийнх нь цорж лам ч гэдэг юм уу,ширээт лам гэдэг нь ямар хүн байсан бол?

Тэр Зандраа гэж лам байсан. Дараагийнх нь лам.

-Унзад, гэсгүй нар нь?

Туранхай Гарам гэж унзад, гэсгүй хүн байсан. Одоо манай сумд Ширнэн Мөнх гэдэг настай хүн бий. Тэр нэг мэдэж магад. Өөр настай хүн байхгүй. Тэр надаас ах юм болохоор мэдэх байх.

-Цагаан-Овооны хийдийн лам нар Халх голд байхдаа хийдтэй байсан юм болов уу? Эсвэл энд ирээд л хийд байгуулав уу?

Энд ирээд байгуулсан. Тэнд сэргэсэн юм гэж байхгүй байх. 4 настай Халх голоос ирсэн хүн. Тэрийг ёстой мэдэхгүй байна.

-Хийд хэдэн онд баларсан юм бол?

1937 онд. Эсэргүү гэж бүгдийг нь бариад лам нар үгүй болоход.

-Хийдийг хэзээ хааж нураасан бэ?

Эхлээд лам нарыг нь бариад бүгдийг шоронд хийчихсэн. Тэгээд тэр эвдэрий хийд дуганыг тэр хэвээр нь нэг манаатай хэдэн жил байсан юм. 2 жил байсан.

-Тэгээд хэний тушаалаар хэдийд буулгасан юм бол?

Мэдэхгүй ээ.